



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/235

Мандалговь

Авто замын нөхөөс хийх ажлыг  
хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Авто замын нөхөөс хийх ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ц.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Ж.Уянга (Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
Д.Очбадрах (Хот тохижуулах газрын дарга)  
Т.Дашравдан (Хот тохижуулах газрын зам талбайн инженер)

Нарийн бичгийн дарга: Д.Отгончулуун (Ачлалт баян ХХК-ний менежер)

2. Авто замын нөхөөс хийх ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Ц.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



431150570